



ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.17 № 03/2773
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ДГАХААГ/20240101093 дугаартай "Айраг сумын ЭМТ-ийн 1-р байрны засвар хийх ажил" гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон "Баян улаан констракшн" ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

"Баян улаан констракшн" ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон "Илчдулаан өсөх" ХХК-ийн тендерийн материалтай танилцахад тендер илгээх маягтад захиалагчийн нэрийг буруу бичсэн, ижил төстэй ажил гүйцэтгэсэн болон хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээлэл ирүүлээгүй, санал болгосон дулаан хангамж, сантехникийн инженер тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангахгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу "Илчдулаан өсөх" ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.13-т "Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална" гэж заасан.

"Илчдулаан өсөх" ХХК-ийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр илгээсэн тендерийн маягтад "Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын Тамгын газарт" гэсэн нь шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Шаардана." гэж заасны дагуу "Илчдулаан өсөх" ХХК тендерт ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээллийг ирүүлсэн байх тул маягт 4, маягт 6-г ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "Ажил гүйцэтгэх хүний нөөц: Шаардана...-Дулаан хангамж, сантехникийн инженер-1,

9766005120

Тухайн байгууллагад 1-ээс доошгүй жил ажилсан байх, диплом хавсарган ирүүлэх. - Дулаан хангамж, сантехникийн инженер мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх, нотлох баримт хавсаргах..." гэж заасан байна.

"Илчдулаан өсөх" ХХК тендерт 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 047-24 тоот албан бичигт Х.Буянхүүг дулаан хангамж, сантехникийн инженерээр санал болгосон бөгөөд Х.Буянхүү нь эдийн засаг, эрчим хүчний зохион байгуулалт, цахилгааны инженер мэргэжлээр төгссөн диплом хавсарган ирүүлсэн байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "...Дулаан хангамж, сантехникийн инженер-1, Тухайн байгууллагад 1-ээс доошгүй жил ажилсан байх, диплом хавсарган ирүүлэх, ... мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх, нотлох баримт хавсаргах" гэж заасан шаардлагад нийцэх эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй байна .

4. "Илчдулаан өсөх" ХХК тендерт хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан "Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана" гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 03/187 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Түүнчлэн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 59.10-т заасан шийдвэр гаргасан, эсхүл гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлаас шалтгаалан захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно." гэж заасан тул танай хүсэлтийн дагуу хугацаа сунгах зөвшөөрөл олгох чиг үүрэг тус яаманд хуулиар олгогдоогүй байна.

Хувийг: "Баян улаан констракшн" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ